

БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны 11 дугаар сарын 25 ны өдөр

**“НИСЭХ БУУДЛЫН ТАЛБАЙД ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ
ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ”-ЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү даатгалын үйлчилгээний ажлын даалгаварт Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа нисэх буудлын талбайд гуравдагч этгээдэд гарах эрсдэлийг даатгуулах даатгалын үйлчилгээний шаардлагыг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 2.1 Даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь эрсдэл даах чадвар бүхий давхар даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай байна.
- 2.2 Давхар даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь олон улсын нэр хүнд бүхий байгууллага /А- буюу түүнээс дээш үнэлгээтэй/ байна.
- 2.3 Давхар даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ижил төрлийн давхар даатгалын үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байна. /Туршлагын талаарх танилцуулгыг албан мэдэгдлийн хамт ирүүлэх/
- 2.4 Даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь Давхар даатгалын үйлчилгээ үзүүлэгчээс давхар даатгалын үйлчилгээг үзүүлэхийг нотолсон албан ёсны баримт бичгийг ирүүлнэ.
- 2.5 Дээр дурдсан баримт бичгийг баримт бичгийн хүчин төгөлдөр шаардлагыг хангах үүднээс тухайн улсын нотариатаар баталгаажуулсан байна.

3. ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

	ДААТГУУЛАГЧ:	ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
1	ДААТГАЛЫН НИЙТ ҮНЭЛГЭЭ :	1,000,000,000,000.00₮ (нэг их наяд төгрөг)
2	ХУГАЦАА:	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 365 хоног

3	НИЙТЛЭГ ШААРДЛАГА:	<ul style="list-style-type: none"> - Хохирол нөхөн төлөлтийн харьцаа 40%-иас дээш; - 24/7 үйлчилгээ үзүүлэх боломжтой байх; - Эрсдэлээс хамгаалах, бууруулах чиглэлд хамтран ажиллах;
4	ДААТГАЛЫН ЭРСДЭЛ:	<ul style="list-style-type: none"> - Гал, түймэр, ус дамжуулах, зайлуулах, сувгийн гэмтэл, нисэх буудлын механикжсан болон тусгай тоног төхөөрөмжийн гэмтэл, даатгуулагчийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмж, барилга байгууламжийн дефект, нисэх буудлын нутаг дэвсгэрт даатгуулагчийн ажилтны жолоодож байсан тээврийн хэрэгсэл, газрын тусгай үйлчилгээний техникээр мөргөх, дайрах, даатгуулагчийн чанарын шаардлага хангаагүй ажил үйлчилгээнээс нисэх буудал болон агаарын хөлөгт хэрэглэгчийн бараа дутах, түүнчлэн үзүүлж буй үйлчилгээний талаар хангалттай мэдээлэлгүй, санамсаргүй алдаа гаргах, эсвэл нисэх буудлын ажилтнуудын мэргэжлийн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй зэрэг даатгуулагчийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой нөхцөлүүд; - Нисэх буудлын барилга болон түүнд хамаарах барилга байгууламжид байгаа зорчигч болон гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд, учирсан хохирол (нойтон шалан дээр унах, автомат хаалга, эксалаторын эвдрэл, зар сурталчилгааны самбар унах зэрэгт цохиулах, ресторан, кафены хүнсэнд хордох зэрэг урьдчилан харах боломжгүй тохиолдлууд) - Зорчигч болон гуравдагч этгээдийн эд хөрөнгө устаж гэмтэх (гар тээш, ачаа, агаарын хөлөг, тээврийн хэрэгсэл, барилга, байгууламж, павильон, дэлгүүр, тоног төхөөрөмж) гэх мэт - Нисэх буудлуудын хамгаалагдсан болон хориотой бүс дотор ИНҮТ-ийн харьяа алба, салбаруудын үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнуудын мэргэжлийн ур чадвар дутагдсанаас санамсаргүй гаргасан алдаанаас болсон хохирлууд - Нисэх буудлуудын хамгаалагдсан болон хориотой бүс дотор ИНҮТ-ийн харьяа алба, салбаруудын үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаандаа ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг урьдчилан харах боломжгүй гэнэтийн эвдрэл, гэмтлээс шалтгаалан гарах хохирлууд, аэродромуудын хөдөлгөөний хэсгүүдийн

		<p>үйлчилгээ, аэродромоос хөөрч бууж буй агаарын хөлгүүдэд учирсан хохирлууд</p> <ul style="list-style-type: none"> - "Чингис Хаан" олон улсын нисэх буудлын аэродромын аюулгүй бүсэд агаарын тээвэрлэгч нарын агаарын хөлгийн шатахууныг "Шатахуун хангамжийн байгууламжид хүлээн авах, хадгалах, ачих, агаарын хөлөг цэнэглэх үйлчилгээ (Цэнэглэгч машин болон гидрант систем)-ний явцад учирсан хохирол
5	ДААТГАЛ ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ:	<ol style="list-style-type: none"> 1. "Чингис Хаан" олон улсын нисэх буудал 2. Буянт-Ухаа олон улсын нисэх буудал 3. Баянхонгор аймаг дахь Баянхонгор нисэх буудал 4. Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудал 5. Ховд аймаг дахь Ховд нисэх буудал 6. Дорнод аймаг дахь Чойбалсан нисэх буудал 7. Говь-Алтай аймаг дахь Алтай нисэх буудал 8. Баян-Өлгий аймаг дахь Өлгий нисэх буудал 9. Хөвсгөл аймаг дахь Хатгал нисэх буудал. 10. Булган аймаг дахь Булган нисэх буудал 11. Өвөрхангай аймаг дахь Арвайхээр нисэх буудал 12. Өвөрхангай аймаг дахь Хархорин нисэх буудал 13. Хэнтий аймаг дахь Өндөрхаан нисэх буудал 14. Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудал 15. Завхан аймаг дахь Тосонцэнгэл нисэх буудал 16. Өмнөговь аймаг дахь Гурвансайхан нисэх буудал 17. Увс аймаг дахь Дэглий цагаан нисэх буудал 18. Завхан аймаг дахь Доной нисэх буудал 19. Дундговь аймаг дахь Мандалговь нисэх буудал 20. Хэнтий аймаг дахь Дэлүүнболдог нисэх буудал 21. Ховд аймаг дахь Булган нисэх буудал
6	НЭМЭЛТ:	<ul style="list-style-type: none"> - Хохирлыг үнэлгээний зардал; - Шүүхийн зардал; - Өмгөөлөгчийн зардал; - Холбогдон гарах бусад зардлууд;


7	ӨӨРИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА:	Олон улсын давхар даатгалын стандарт нөхцөлийн дагуу
---	------------------------------	---

Ажлын даалгавар боловсруулсан:


Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү,
эдийн засаг, төлөвлөлтийн газрын дарга,
Үнэлгээний хорооны дарга:

 Ч. Сэржмаа


Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн,
Үнэлгээний хорооны нарийн бичиг:

 Б. Алтангэрэл


Иргэний нисэхийн үндэсний төвийн Аэродром,
гэрэл суултын албаны аэродром ашиглалтын
хэсгийн дарга,
Үнэлгээний хорооны гишүүн:

 Ж. Тулга

“Сэтгэлзүй судалгаа, мэдээллийн төв”
Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:

 Б. Мэндсайхан

“ХУД Яармаг”
Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:

 Г. Ганчимэг